



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 12 сарын 26 өдөр

Дугаар 802

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 168, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Далайн захиргааны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 45,226,225.00 (дөчин таван сая хоёр зуун хорин зургаан мянга хоёр зуун хорин тав) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий Тоёота Камри маркийн 03-98 УНУ улсын дугаартай автомашиныг ашиглах хугацааг 2 жилээр сунгаж, үнийг 10,000,000.00 (арван сая) төгрөгөөр шинэчлэн тогтоож, Хилийн боомтын захиргаанд (Ховд аймаг дахь Хилийн Булган авто замын боомт) хавсралтын дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Монгол Улсын Далайн захиргааны дарга Д.Отгонсүрэн, Хилийн боомтын захиргааны дарга Б.Батхишиг, нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлэн, арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-г үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

123006832
37-r huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 12 дугаар сарын 26 -ны өдрийн
802 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ДАЛАЙН ЗАХИРГААНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

Д/д	Автомашинны нэр, марк, улсын дугаар, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)		Хүлээн авах байгууллагын нэр
				Цаашид ашиглах хугацаа (жилээр)	Нийт үнэ (төгрөг)	
1	Тоёота Камри 03-98 УНУ /Арал № 6Т1ВF9FK2DX416200/	12/11/2012	45,226,225.00	2	10,000,000.00	Хилийн боомтын захиргаанд /Ховд аймаг дахь Хилийн Булган авто замын боомт/
				45,226,225.00	10,000,000.00	
Нийт дүн				(дөчин таван сая хоёр зуун хорин зургаан мянга хоёр зуун хорин таван)		(арван сая)